



**“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ТӨХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Журмын шинэчилсэн  
найруулгыг батлах тухай


Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн хуулийн 5.2 дах заалт, “Хөдөө аж ахуйн бирж ХХК –ийн дүрмийн 7.3.5 дахь заалт, Биржийн зохицуулах зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлаас ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны Ерөнхий журмын шинэчилсэн найруулгыг хавсралт ёсоор баталж, 2015 оны 07 сарын 25-ны өдрөөс мөрдсүгэй.
2. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны Ерөнхий журмыг баталсан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 03 сарын 17-ны өдрийн 04 тоот тогтоолыг 2015 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.
3. Үйл ажиллагааны журамд нийцүүлэн дагалдах журмыг баталж, хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЧОЙ-ИШ



## ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмаар Хөдөө аж ахуйн бирж (цаашид “Бирж” гэх)-ийн арилжааны зах зээлд оролцогчдын арилжааны үйл ажиллагаатай холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү харилцааг зохицуулахад “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль” (цаашид “Биржийн тухай хууль” гэх), “Иргэний хууль”, “Компанийн тухай хууль” болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд нээлттэй, шударга, оновчтой байх зарчмыг баримтална.
- 1.3 Биржийн дүрэмд заасны дагуу энэ журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг Биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) батална.
- 1.4 ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрөөс хуанлийн 14 хоногийн өмнө нийтэд мэдэгдэнэ.
- 1.5 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог “Нэр томъёоны тайлбар” (ХАВСРАЛТ)-г тодорхойлсон утгаар ойлгоно.

### Хоёр. Биржийн үйл ажиллагаа

- 2.1 Биржийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн дөрөвдүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт заасны дагуу хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүний баталсан, биржээр арилжаалахжагсаалтад орсон бараа, түүхий эдийг Биржээр арилжаална.
- 2.2 Биржийн тухай хуульд заасны дагуу Биржийн байнгын болон байнгын бус гишүүний арилжаанд оролцох зөвшөөрлийг Биржийн гүйцэтгэх удирдлага олгоно.
- 2.3 Бирж байнгын болон байнгын бус гишүүдийг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, батламжийг Биржийн гүйцэтгэх удирдлага олгоно. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг жил бүр шинэчлэн баталж, шаардлагатай тохиолдолд нэмэлт сургалт зохион байгуулж болно.
- 2.4 Биржээс тогтоосон шалгуурыг хангасан агуулах, тээврийн байгууллагад итгэмжлэл олгохтой холбоотой ажлыг Бирж зохион байгуулна.
- 2.5 Биржийн арилжааны мэдээ, тэдгээрийн төрөл, ангиллыг Биржийн гүйцэтгэх удирдлага батална. Нийтэд зориулсан арилжааны мэдээ, холбогдох тайланг тогтмол мэдээлнэ. Эрх бүхий байгууллагын албан хүсэлтийн дагуу боломжит мэдээллийг өгч болно.

- 2.6 Бирж нь арилжаалахгэрээг бүртгэх, гэрээний төлбөр тооцоог хийх, гэрээ халгалах үйлчилгээг гүйцэтгэх “Клиринг, төлбөр тооцооны нэгж”-тэй байна. Тус нэгжийн үйл ажиллагааг энэ журам болон нэгжийн дотоод журмаар зохицуулна.
- 2.7 “Клиринг, төлбөр тооцооны нэгж”-ийн дотоод журмыг Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- 2.8 Биржийн гишүүний гишүүнчлэлийн хураамж, арилжааны шимтгэл, төлбөр тооцооны шимтгэлийн хэмжээг ТУЗ тогтооно.

**Гурав. Биржээр арилжаалах бараа, түүхий эд**

- 3.1 Биржээр арилжаалах жагсаалтад орсон бараа, түүхий эдийг гэрээ хэлбэрээр арилжаална. Гэрээний тодорхойлолтыг Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- 3.2 Биржээр Биржийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан гэрээг арилжаална.
- 3.3 Биржээр арилжаалсан гэрээний талууд “Иргэний хууль” болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт заасан эрх, үүргийг эдэлнэ.

**Дөрөв. Гишүүнчлэл**

- 4.1 Биржийн гишүүнээр элсэх, биржийн гишүүний эрх үүргийг хэрэгжүүлэх, биржийн гишүүний эрх зүйн чадамжтай холбоотой асуудлаар Бирж болон түүний гишүүний хооронд үүсэх нийтлэг харилцааг энэ журам болон Гишүүнчлэлийн журмаар, бусад харилцааг биржийн гишүүнчлэлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна.
- 4.2 Биржийн гишүүний ажлын байр, хүний нөөц, санхүү, техникийн шалгуур үзүүлэлтийг Биржийн гүйцэтгэх удирдлага батлах ба биржийн гишүүний шалгуур үзүүлэлтийг хангасан хуулийн этгээдтэй гишүүнчлэлийн гэрээ байгуулна.
- 4.3 Биржийн гүйцэтгэх удирдлага холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд биржийн гишүүнд дараах эрхүүдийг бүхэлд нь болон хэсэгчлэн олгох эрхийг эдэлнэ. Үүнд:
  - 4.3.1 Гишүүнчлэлийн;
  - 4.3.2 Арилжааны;
  - 4.3.3 Клирингийн;
  - 4.3.4 Зах зээл үүсгэх
- 4.4 Биржийн гүйцэтгэх удирдлага энэхүү журмын 4.3-т зааснаас гадна Биржийн гишүүний үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд сануулах, эрхийгтүдгэлзүүлэх, цуцлах эрхийг эдэлнэ.
- 4.5 Биржийн гишүүн нь байнгын болон байнгын бус гэсэн хоёр төрөлтэй байна. Үүнд:
  - 4.5.1 Биржийн байнгын гишүүн нь иргэн, хуулийн этгээдийг арилжаанд зуучлах, өөрийн нэрийн өмнөөс болон биржээс зөвшөөрсөн бусад хэлбэрээр арилжаанд оролцож болно.

- 4.5.2 Биржийн байнгын бус гишүүн нь өөрийн нэрийн өмнөөс болон биржээс зөвшөөрсөн бусад хэлбэрээр арилжаанд оролцож болно.

### Тав. Арилжаа

- 5.1 Арилжааны эрхтэй гишүүн нь арилжаанд бие дааж оролцоно. Тэдгээрийн харилцагчид гишүүнээр дамжуулан арилжаанд оролцоно.
- 5.2 Арилжааг биржийн гэрээний тодорхойлолтод заасан арилжааны хуваарийн дагуу бирж зохион байгуулна.
- 5.3 Бирж нь арилжааг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:
- 5.3.1 Танхимын арилжаа;
  - 5.3.2 Онлайн арилжаа.
- 5.4 Арилжааг “Арилжаа хөтлөгч” зохион байгуулах ба дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
- 5.4.1 Арилжааны бэлтгэл ажлыг хангах;
  - 5.4.2 Арилжааг нээх, хаах, түр зогсоох;
  - 5.4.3 Арилжааны журмыг мөрдүүлэх;
  - 5.4.4 Арилжааны журамд заасан бусад.
- 5.5 Арилжаанд дараах төрлийн захиалгыг оруулж болно. Үүнд:
- 5.5.1 Зах зээлийн захиалга;
  - 5.5.2 Нөхцөлт захиалга;
  - 5.5.3 Кросс захиалга;
  - 5.5.4 Зах зээл үүсгэгчийн захиалга;
  - 5.5.5 Арилжааны системд зөвшөөрсөн бусад.
- 5.6 Арилжаанд оролцогч энэ журмын 5.5-д заасан захиалгад Арилжааны журамд заасан нэмэлт нөхцөлүүдийг оруулж болно.
- 5.7 Биржийн гүйцэтгэх удирдлага гэрээний онцлог, арилжаанд оролцогчийн эрх, үүрэгт тохируулсан захиалгын хэмжээ, үнийн саналын хязгаарлалтыг хийж болно. Хязгаарлалтыг биржийн гэрээний тодорхойлолтод тусгана.
- 5.8 Арилжаанд оролцогч нь арилжааны системд биржийн бараа авах/зарах захиалга оруулах, өөрийн захиалгын нөхцлийг өөрчлөх, цуцлах зэрэг арилжааны системд зөвшөөрөгдсөн үйлдлийг хийж болно.
- 5.9 Арилжааны системд оруулж буй захиалга бүрт үнэ болон цаг хугацааны дарааллын дагуу эрэмбэлэн, дугаар олгоно. Авах, зарах зах зээлийн болон нөхцөлт захиалгын үнээс цахим хэлцэл гүйцэтгэгдэх үнийг бодож гарган, тохирох захиалгуудыг захиалгын төрөл, үнэ, цаг хугацааны дарааллаар нь биелүүлдэг.
- 5.10 Кросс захиалгаар хийгдэх хэлцлийн үнийг арилжааны системийн захиалгын бүртгэлээр оруулах боловч үнэ тогтооход оруулахгүй, зөвхөн арилжааны мэдээнд оруулна.

- 5.11 Арилжаанд оролцогч нь энэ журмын 5.5-д заасан захиалгуудыг арилжаанд оруулж буй нь хэлцэл биелүүлэхэд бэлэн байгааг илэрхийлнэ.
- 5.12 Арилжаанд оролцогчийн нийт захиалга арилжааны системийн мэдээллийн санд бүртгэгдэнэ.
- 5.13 Биржээр арилжаалж буй гэрээний үнийг тооцохдоо биржийн гэрээний тодорхойлолтод заасан аргачлалыг ашиглана. Биржийн гэрээний тодорхойлолтод дараах аргаас аль нэгийг заасан байна. Үүнд:
  - 5.13.1 Дуудлага худалдаа: Арилжаанд олон худалдагч, олон худалдан авагч оролцоно. Арилжааны үед нэг үнэ тогтож, тухайн үнийг хүлээн зөвшөөрсөн захиалгууд биелнэ. Энэ аргын хувьд хамгийн их хэмжээ бүхий гэрээнүүд арилжаалах боломжтой үнийг сонгох зарчим баримтална.
  - 5.13.2 Үргэлжилсэн арилжаа/худалдаа: Арилжааны үеийн турш хамгийн сайн үнийн санал бүхий захиалгууд биелнэ. Энэ аргын хувьд эхэлж оруулсан захиалга эхэнд биелэх зарчим баримтална.
  - 5.13.3 Англи дуудлага худалдаа: Арилжаанд нэг худалдагч, олон худалдан авагч оролцоно. Зарах тал зарах доод үнээ, барааны хэмжээтэй хамт өгөх ба хамгийн сайн үнийн санал өгсөн захиалгууд биелнэ. Үнэ хугацаа гэсэн дарааллыг мөрдөж, төлбөр тооцоог захиалгад өгсөн үнийн саналаар гүйцэтгэнэ.
  - 5.13.4 Нэг багц бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдаа: Арилжаанд нэг багц барааг зарах нэг худалдагч, олон худалдан авагч оролцоно. Зарах тал зарах доод үнээ өгөх ба хамгийн сайн үнийн санал өгсөн захиалгууд биелнэ. Үнэ хугацаа гэсэн дарааллыг мөрдөж, төлбөр тооцоог захиалгад өгсөн хоёр дахь сайн үнийн саналаар гүйцэтгэнэ.
  - 5.13.5 Олон багц бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдаа: Арилжаанд олон багц барааг зарах нэг худалдагч, олон худалдан авагч оролцоно. Зарах тал зарах доод үнэ, хэмжээгээ өгч, авах тал авах үнэ, хэмжээгээ оруулна. Хамгийн сайн үнийн санал өгсөн захиалгууд биелэх буюу хугацаа гэсэн дарааллыг мөрдөнө. Төлбөр тооцоог биелсэн захиалгуудын хамгийн бага үнийн саналаар гүйцэтгэнэ.

### **Зургаа. Клиринг**

- 6.1 Биржийн “Клиринг, төлбөр тооцооны нэгж” клирингийн үйлчилгээг цахим горимд гүйцэтгэнэ.
- 6.2 Арилжаанд оролцогч нь биржийн гэрээний тодорхойлолтод заасан дэнчинг дэнчингийн дансанд байршуулсан байна.
- 6.3 Дэнчин дараах төрөлтэй байна. Үүнд:
  - 6.3.1 Баталгаат дэнчин: Энэ дэнчинг байнгын гишүүн өөрийн болон харилцагчийн тогтворт дэнчингийн зохистой хэмжээг хангахад ашиглана.
  - 6.3.2 Анхдагч дэнчин: Арилжаанд оролцогч нь зөвхөн анхдагч дэнчинд харгалзах дүн хүртэл захиалгыг арилжааны системд оруулж болно. Спот арилжааны төлбөр тооцоонд анхдагч дэнчинг ашиглахгүй.

- 6.3.3 Тогтворт дэнчин: Энэ дэнчинг төлбөр тооцоонд ашиглахгүй.
- 6.3.4 Хүргэлтийн дэнчин: Энэ дэнчинг хэлцэл баталгаажсанаас хойш биет хүргэлт хийгдэх хүртэл байршуулна.
- 6.4 Дэнчинг арилжаанд оролцогчийн албан хүсэлтээр клиринг, төлбөр тооцооны системд бүртгэгдсэн данс руу нь буцаан шилжүүлнэ.
- 6.5 “Клиринг, төлбөр тооцооны нэгж” нь биржээр арилжаалсан гэрээний хэрэгжилт болох мөнгөн хөрөнгийн гүйлгээг хураангуйлах, бараа, түүхий эдийн хүргэлтийг гүйцэтгүүлэхдээ оновчлох зохион байгуулалтыг хийж болно.

### **Долоо. Төлбөр тооцоо**

- 7.1 Биржээр арилжаалсан гэрээний мөнгөн хөрөнгийн гүйлгээг “Клиринг, төлбөр тооцооны нэгж” Монгол Улсынарилжааны банкаар дамжуулан холбогдох хууль, эрх зүйн хүрээнд гүйцэтгэнэ.
- 7.2 Бирж нь арилжааны банкинд баталгаа, дэнчингийн гүйлгээ хийх дэнчингийн данс, биржээр арилжаалсан гэрээний төлбөр тооцоо гүйцэтгэх төлбөр тооцооны данстай байна.
- 7.3 Биржээр арилжаалсан гэрээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд ашиглах үнэ нь арилжаанд оролцогчийн заавал дагаж мөрдөх үнэ байна. Төлбөр тооцоо гүйцэтгэхэд ашиглах үнийг биржийн “Клиринг, төлбөр тооцооны нэгж” тооцно.
- 7.4 Төлбөр тооцоо нь биржээр арилжаалсан гэрээний хүргэлттэй эсэхээс шалтгаалан бэлэн мөнгөний төлбөр тооцоо, хүргэлттэй гэрээний төлбөр тооцоо гэсэн 2 төрөлтэй байна. Биржээр арилжаалсан гэрээний төлбөр тооцоог биржийн гүйцэтгэх удирдлагын баталсан дотоод журамд заасан хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

### **Найм. Логистик**

- 8.1 Итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангах этгээдэд биржийн итгэмжлэл олгоно. Шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- 8.2 Итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаа, эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг Бирж болон итгэмжлэгдсэн этгээдийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна. Гэрээ байгуулсан өдрөөс итгэмжлэл хүсэгч нь итгэмжлэгдсэн этгээд болно.
- 8.3 Итгэмжлэгдсэн этгээд нь биржээс баталсан загварын дагуу хаяг, таних тэмдэгтэй байж болно. Хаяг, таних тэмдгийг биржийн зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.
- 8.4 Итгэмжлэгдсэн этгээд нь дараах хоёр төрөлтэй байх ба итгэмжлэгдсэн этгээдийн эрх, үүргийг Биржтэй байгуулсан гэрээгээр зохицуулна. Үүнд:
- 8.4.1 Итгэмжлэгдсэн агуулах. Итгэмжлэгдсэн агуулахын эзэмшигч нь биржийн гишүүн, эсвэл хуулийн этгээд байж болох ба итгэмжлэгдсэн агуулах нь биржийн барааг агуулахад хүлээн авах, хадгалах, хүлээлгэн өгөх, ачих зэрэг үйлчилгээг харилцагчид үзүүлнэ.

- 8.4.2 Итгэмжлэгдсэн тээвэрлэгч. Итгэмжлэгдсэн тээврийн байгууллага нь хуулийн этгээд байх ба агуулахаас биржийн барааг хүлээн авах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх, буулгах үйлчилгээг харилцагчид үзүүлнэ.
- 8.5 Гэрээний тодорхойлолтод өөрөөр заагаагүй бол Биржээр арилжаалах бараа, түүхий эдийг тухайн бараа, түүхий эдийн төрлөөр итгэмжлэл авсан биржийн итгэмжлэгдсэн агуулахад хадгална.
- 8.6 Арилжаанд оролцогч нь итгэмжлэгдсэн тээврийн байгууллагаар хүргэлт гүйцэтгүүлж болох ба итгэмжлэгдсэн тээврийн байгууллагыг сонгоогүй тохиолдолд тээвэрлэлтийн аливаа эрсдэлийг өөрөө хариуцна.
- 8.7 Биржээр арилжаалах бараа, түүхий эдийн чанар, хэмжээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг Хяналтын журамд заасны дагуу зохицуулна.

#### **Ес. Хяналт**

- 9.1 Биржийн тухай хуульд заасны дагуу Бирж нь хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.1.1 Биржийн дотоод үйл ажиллагааны хяналт;
- 9.1.2 Биржийн гишүүн, итгэмжлэгдсэн этгээд, төлбөр тооцоо гүйцэтгэгч банк, бусад харилцагч байгууллага болон Биржийн хооронд үүсэх харилцаанд тавих хяналт;
- 9.1.3 Биржийн арилжааны хяналт.
- 9.2 Хяналтыг хэрэгжүүлэх хуваарь, арга, хэлбэрийг Хяналтын журмаарнарийвчлан зохицуулна.
- 9.3 Биржээр арилжаалсан гэрээний талууд болон бусад этгээд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн хохирлыг Хяналтын журамд заасны дагуу тодорхойлно.

#### **Арав. Хариуцлага**

- 10.1 Биржийн гишүүн нь гишүүнчлэлийн эрх, арилжааны эрх, клирингийн эрх, зах зээл үүсгэх эрхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд Хяналтын журамд заасны дагуу хариуцлага ногдуулна.
- 10.2 Итгэмжлэгдсэн этгээд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, итгэмжлэлийн гэрээний үүргийг зөрчсөн тохиолдолд Хяналтын журмын дагуу хариуцлага ногдуулна.
- 10.3 Хариуцлага ногдуулах эрхийг Биржийн гүйцэтгэх удирдлага эдэлж, сануулах, түдгэлзүүлэх, цуцлах шийдвэр гаргана.

--oOo--